САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
FINANCIAL REGULATORY COMMISSION OF MONGOLIA

# ДААТГАЛЫН САЛБАРЫН 2015 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

УЛААНБААТАР ХОТ
2015 оны 11 дүгээр сар

ТАНИЛЦСАН:

| | |
|---|---|
| ХОРООНЫ ДАРГА | З. НАРАНТУЯА |
| ДЭД ДАРГА | Х. БУМ-ЭРДЭНЭ |
| ДЭД ДАРГА | Э. БАТБОЛД |
| АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА | Б.БАТСЭЛЭНГЭ |

ХЯНАСАН:

| | |
|---|---|
| ДААТГАЛЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА | Ц.НАЦАГДОРЖ |

БОЛОВСРУУЛСАН:

| | |
|---|---|
| ДААТГАЛЫН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ХЯНАН ШАЛГАГЧ | Ц.ДАШНЯМ |

**ГАРЧИГ**

ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ_ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ_ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 3

ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ_ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ 4

ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ_ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ 6

ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО_ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО 8

ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР_ ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР 10

ДААТГАЛЫН НӨӨЦ САН_ДААТГАЛЫН НӨӨЦ САН 12

ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА_ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА 12

ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА_ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА 14

ДАВХАР ДААТГАЛ_ДАВХАР ДААТГАЛ 15

ЕРДИЙН ДААТГАЛ_ЕРДИЙН ДААТГАЛ

ЕРДИЙН ДААТГАГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ_ЕРДИЙН ДААТГАГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ 16

ЕРДИЙН ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ_ЕРДИЙН ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ 16

ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО_ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО 16

ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР_ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР 17

ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА, АШИГТ АЖИЛЛАГАА_ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА, АШИГТ АЖИЛЛАГАА 17

ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН, ДАВХАР ДААТГАЛ_ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН, ДАВХАР ДААТГАЛ 18

УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ_УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ 20
УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨР. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨР 20
УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ 21
УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН НӨӨЦ САН, АШИГТ АЖИЛЛАГАА. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН НӨӨЦ САН, АШИГТ АЖИЛЛАГАА 21
АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ. АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ 22
ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ
ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ 23
ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ. ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ 25
ДҮГНЭЛТ. ДҮГНЭЛТ 26

## 1. ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

### 1.1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2015 оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, хөдөө аж ахуйн давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 34, даатгалын хохирол үнэлэгч 24 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Мөн даатгалын компанийн салбар болон төлөөлөгчийн газар 255, даатгалын зуучлагч компанийн 168 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 52 салбар Хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа нь арилжааны даатгалын борлуулалтын сувгийг нэмэгдүүлж, иргэдэд хүрэх даатгалын хүртээмжийг нэмэгдүүлж байна.

Хүснэгт -1

**Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо**

| № | | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015.III |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ердийн даатгалын компани | 17 | 16 | 16 | 17 | 16 | 16 | 15 |
| 2 | Урт хугацааны даатгалын компани | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 3 | Давхар даатгалын компани | | | | | | | 1 |

Даатгалын зохицуулалтын газар: Даатгалын салбарын 2015 оны 3 дугаар улирлын нэгдсэн танилцуулга

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **4** | Даатгалын төлөөлөгч | 1676 | 2061 | 2057 | 2357 | 3187 | 3260 | 3314 |
| **5** | Даатгалын зуучлагч | 5 | 9 | 8 | 17 | 20 | 30 | 34 |
| **6** | Даатгалын хохирол үнэлэгч | 2 | 6 | 9 | 9 | 14 | 20 | 24 |
| **7** | Актуарч | 10 | 12 | 13 | 18 | 15 | 15 | 15 |
| | **БҮГД** | **1711** | **2105** | **2104** | **2419** | **3253** | **3244** | **3342** |

Хүснэгт-2

**Даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогч компаниудын салбарын тоо**

| № | | 2013 | 2014 | 2015.III |
|---|---|---|---|---|
| **1** | Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газар | 251 | 254 | 255 |
| **2** | Даатгалын зуучлагч компанийн салбар | 64 | 135 | 168 |
| **3** | Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар | 8 | 42 | 52 |
| | **БҮГД** | **323** | **431** | **481** |

***2015 оны 3-р улиралд:*** Хорооны 2015 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 348 дугаар тогтоолоор “Тус брокерс” ХХК даатгалын зуучлалын чиглэлээр, 9 дүгээр сарын 11-ний өдрийн 365 дугаар тогтоолоор “Банхас” ХХК даатгалын хохирол үнэлгээний чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан байна.

## 1.2. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

Тайлант улиралд даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 2015 оны 3 дугаар улиралд 169.6 тэрбум төгрөг байгаа нь өмнөх тайлант он буюу 2014 оны 4 дүгээр улиралтай харьцуулахад 17.1 тэрбум төгрөгөөр буюу 11.2 хувиар өссөн бөгөөд 2015 оны 2 дугаар улиралтай харьцуулахад 1 тэрбум гаруй төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Үүнд өмнөх улирлын нийт хөрөнгөөс 100 сая болон түүнээс дээш төгрөгөөр буурсан 5 даатгалын компанийн нийт хөрөнгийн бууралт гол нөлөөлсөн байна.

График-1

График-2

Манай улсын даатгалын зах зээлийн хөгжилд урт хугацааны даатгалын өсөлт болон давхар даатгалын тогтолцоо зайлшгүй шаардлагатай байна.

Хүснэгт-3

**Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ**

| № | Компани | Нийт хөрөнгийн хэмжээ | | | Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Эргэлтийн хөрөнгө | Эргэлтийн бус хөрөнгө | Хөрөнгө | |
| 1 | **Ард даатгал** | 7,283,846,405.43 | 1,570,127,889.72 | 8,853,974,295.15 | 5.2% |
| 2 | **Бодь даатгал** | 9,640,076,706.91 | 1,902,947,726.52 | 11,543,024,433.43 | 6.8% |
| 3 | **Ган зам даатгал** | 5,227,299,482.34 | 171,642,534.18 | 5,398,942,016.52 | 3.2% |
| 4 | **Гэр даатгал** | 4,707,576,172.11 | 44,493,835.82 | 4,752,070,007.93 | 2.8% |
| 5 | **Мандал женерал даатгал** | 9,057,159,265.00 | 568,571,471.15 | 9,625,730,736.15 | 5.7% |
| 6 | **Миг даатгал** | 8,290,731,705.64 | 2,109,802,559.09 | 10,400,534,264.73 | 6.1% |
| 7 | **Монгол даатгал** | 16,002,566,054.26 | 10,592,322,625.00 | 26,594,888,679.26 | 15.7% |
| 8 | **Монре даатгал** | 4,913,977,582.87 | 817,590,871.93 | 5,731,568,454.80 | 3.4% |
| 9 | **Мөнх даатгал** | 3,196,329,451.00 | 1,075,007,552.00 | 4,271,337,003.00 | 2.5% |
| 10 | **Номин даатгал** | 8,287,435,979.67 | 0.00 | 8,287,435,979.67 | 4.9% |
| 11 | **Нэйшнл лайф даатгал** | 4,166,947,652.16 | 2,680,445,631.52 | 6,847,393,283.68 | 4% |
| 12 | **Практикал даатгал** | 7,578,048,784.08 | 1,381,256,704.46 | 8,959,305,488.54 | 5.3% |
| 13 | **Соёмбо даатгал** | 6,571,231,208.28 | 2,562,102,237.14 | 9,133,333,445.42 | 5.4% |
| 14 | **Тэнгэр даатгал** | 10,914,627,450.94 | 1,170,670,174.64 | 12,085,297,625.58 | 7.1% |
| 15 | **Улаанбаатар хотын даатгал** | 4,119,245,305.51 | 1,485,872,802.81 | 5,605,118,108.32 | 3.3% |
| 16 | **Хаан даатгал** | 5,338,790,904.86 | 899,558,496.41 | 6,238,349,401.27 | 3.6% |
| 17 | **ХАА-н давхар даатгал** | 25,041,586,695.40 | 223,828,767.22 | 25,265,415,462.62 | 14.9% |
| | **НИЙТ** | **140,337,476,806.46** | **29,256,241,879.61** | **169,593,718,686.07** | 100% |

Нийт хөрөнгөөс эргэлтийн хөрөнгийг бүтцээр нь авч үзвэл 81.1 тэрбум төгрөгийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, 37.4 тэрбум төгрөгийн богино хугацаатай хөрөнгө оруулалт, 18.3 тэрбум төгрөгийн дансны авлага, 3.5 тэрбум төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгөтэй байна. Эргэлтийн хөрөнгө нь нийт дүнгээрээ өмнөх оны мөн үеэс 23.9 тэрбум төгрөгөөр буюу 20.6 хувиар өссөн байна.

Хүснэгт-4

**Эргэлтийн хөрөнгийн бүтэц**

| **Үзүүлэлтүүд** | **2014.III** | | **2015.III** | | **Өсөлт /бууралт/** | |
|---|---|---|---|---|---|---|
| | төгрөгөөр | Эзлэх хувь | төгрөгөөр | Эзлэх хувь | төгрөгөөр | хувиар |
| Мөнгө ба түүнтэй адилтгах | 56,533,556,139.90 | 48.59 % | 81,075,492,933.45 | 57.8 % | 24,541,936,793.55 | 43.4% |

Даатгалын зохицуулалтын газар: Даатгалын салбарын 2015 оны 3 дугаар улирлын нэгдсэн танилцуулга

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| хөрөнгө | | | | | | |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 38,057,646,785.72 | 32.71 % | 37,392,826,064.51 | 26.6 % | -664,820,721.21 | -1.75% |
| Дансны авлага | 18,485,217,209.75 | 15.89 % | 18,331,314,804.85 | 13.1 % | -153,902,404.90 | -0.83% |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 3,276,220,846.44 | 2.82% | 3,537,843,003.65 | 2.5% | 261,622,157.21 | 7.99% |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | 116,352,640,981.81 | | 140,337,476,806.46 | | 23,984,835,824.65 | 20.61 % |

График-3

## 1.3. ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

2015 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөр 1.4 тэрбум төгрөгөөр буурч, нөөц сан 7.8 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 28.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Өмнөх оны мөн үеэс хамгийн өндөр өсөлт үзүүлсэн буюу 45.1 хувиар өссөн эзэмшигчдийн өмчийн өсөлтөд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн эзэмшигчдийн өмчийн хэмжээ гол нөлөө үзүүлсэн байна.

График-4

Тайлант улирлын даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, өр төлбөр, эзэмшигчдийн өмчийн эзлэх хэмжээг сүүлийн 4 жилийн 4 дүгээр улирлын байдалтай харьцуулан график 4-т харуулав. Мөн хүснэгт 5, 6-д дэлгэрэнгүй тоон мэдээллийг нэгтгэсэн.

Хүснэгт-5

| Үзүүлэлтүүд | 2014.III | | 2015.III | | Өсөлт /бууралт/ | |
|---|---|---|---|---|---|---|
| | төгрөгөөр | эзлэх хувь | төгрөгөөр | эзлэх хувь | төгрөгөөр | хувиар |
| Өр төлбөр | 7,006,239,164.67 | 5.2% | 5,619,575,731.26 | 3.3% | -1,386,663,433.41 | -19.79% |
| Нөөц сан | 65,994,568,192.89 | 48.8% | 73,841,962,708.82 | 43.5% | 7,847,394,515.93 | 11.89% |
| Эзэмшигчийн өмч | 62,133,923,986.87 | 45.9% | 90,132,180,245.99 | 53.2% | 27,998,256,259.12 | 45.06% |
| **Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн** | 135,134,731,344.43 | | 169,593,718,686.07 | | 34,458,987,341.64 | 25.50% |

Хүснэгт-6

**Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмч**

| № | Компани | Нийт төлбөр | | Эзэмшигчдийн өмч | Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч |
|---|---|---|---|---|---|
| | | Өр төлбөр | Нөөц сан | | |
| 1 | **Ард даатгал** | 981,780,594.39 | 3,922,676,693.91 | 3,949,517,006.85 | 8,853,974,295.15 |
| 2 | **Бодь даатгал** | 258,206,046.44 | 7,277,424,859.28 | 4,007,393,527.71 | 11,543,024,433.43 |
| 3 | **Ган зам даатгал** | 103,678,354.00 | 1,016,346,037.27 | 4,278,917,625.25 | 5,398,942,016.52 |
| 4 | **Гэр даатгал** | 38,549,197.50 | 805,558,500.03 | 3,907,962,310.40 | 4,752,070,007.93 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | **Мандал женерал даатгал** | 1,595,681,997.41 | 3,608,554,350.02 | 4,421,494,388.72 | 9,625,730,736.15 |
| 6 | **Миг даатгал** | 27,222,264.70 | 5,827,251,237.00 | 4,546,060,763.03 | 10,400,534,264.73 |
| 7 | **Монгол даатгал** | 905,600,284.17 | 16,880,023,015.52 | 8,809,265,379.57 | 26,594,888,679.26 |
| 8 | **Монре даатгал** | 82,100,230.86 | 2,006,239,878.08 | 3,643,228,345.86 | 5,731,568,454.80 |
| 9 | **Мөнх даатгал** | 35,240,334.00 | 524,710,554.00 | 3,711,386,115.00 | 4,271,337,003.00 |
| 10 | **Номин даатгал** | 198,059,189.26 | 4,460,445,082.80 | 3,628,931,707.61 | 8,287,435,979.67 |
| 11 | **Нэйшнл лайф даатгал** | 33,164,361.94 | 1,497,342,334.39 | 5,316,886,587.35 | 6,847,393,283.68 |
| 12 | **Практикал даатгал** | 171,534,242.64 | 4,415,509,760.19 | 4,372,261,485.71 | 8,959,305,488.54 |
| 13 | **Соёмбо даатгал** | 210,518,729.44 | 3,953,220,111.68 | 4,969,594,604.30 | 9,133,333,445.42 |
| 14 | **Тэнгэр даатгал** | 739,494,439.96 | 6,592,948,057.25 | 4,752,855,128.37 | 12,085,297,625.58 |
| 15 | **Улаанбаатар хотын даатгал** | 7,355,287.47 | 1,656,098,187.00 | 3,941,664,633.85 | 5,605,118,108.32 |
| 16 | **Хаан даатгал** | 100,402,211.56 | 2,397,614,050.40 | 3,740,333,139.31 | 6,238,349,401.27 |
| 17 | **ХАА-н давхар даатгал** | 130,987,965.52 | 7,000,000,000.00 | 18,134,427,497.10 | 25,265,415,462.62 |
| | **НИЙТ** | 5,619,575,731.26 | 73,841,962,708.82 | 90,132,180,245.99 | **169,593,718,686.07** |

## 1.4. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд даатгалын компаниуд 832911 иргэд, албан байгууллагатай даатгалын гэрээ байгуулж, 89.1 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлжээ. Даатгалын нийт хураамжийн орлогын 98.5 хувь буюу 87.8 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 1.5 хувь буюу 1.3 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани төвлөрүүлсэн байна. Даатгалын компаниудаас 20 тэрбум ба түүнээс дээш төгрөгийн даатгалын нийт хураамжийн орлого төвлөрүүлсэн 2 компанид зах зээлийн нийт хураамжийн орлогын 48.9 хувь нь ногдож байна. Энэ улирлын даатгалын нийт хураамжийн орлогын өсөлтийн хувь нь сүүлийн 5 жилийн 3 дугаар улирлын байдлаарх дундаж өсөлтийн хувиас доогуур байна.

График-5

Хүснэгт-7

**Даатгалын хураамжийн орлого**

| № | Даатгалын компани | Даатгалын нийт хураамжийн орлого | Давхар даатгалын хураамж | Буцаасан даатгалын хураамж | Даатгалын цэвэр хураамжийн орлого |
|---|---|---|---|---|---|
| 1 | **Ард даатгал** | 6,176,781,233.76 | 1,367,656,851.83 | 80,260,047.55 | 4,728,864,334.38 |
| 2 | **Бодь даатгал** | 23,174,521,877.55 | 16,248,389,065.60 | 163,532,934.71 | 6,762,599,877.24 |
| 3 | **Ган зам даатгал** | 481,827,215.60 | 0.00 | 653,413.03 | 481,173,802.57 |
| 4 | **Гэр даатгал** | 228,874,371.70 | 0.00 | 1,285,546.50 | 227,588,825.20 |
| 5 | **Мандал женерал даатгал** | 6,437,184,758.59 | 4,309,967,402.43 | 183,781,246.17 | 1,943,436,109.99 |
| 6 | **Миг даатгал** | 7,679,413,251.08 | 765,949,374.21 | 148,260,433.48 | 6,765,203,443.39 |

| 7 | **Монгол даатгал** | 20,403,161,999.56 | 9,722,561,478.29 | 410,333,335.56 | 10,270,267,185.71 |
|---|---|---|---|---|---|
| 8 | **Монре даатгал** | 2,309,120,246.66 | 27,933,915.36 | 81,561,374.93 | 2,199,624,956.37 |
| 9 | **Мөнх даатгал** | 399,121,731.00 | 0.00 | 0.00 | 399,121,731.00 |
| 10 | **Номин даатгал** | 2,959,680,897.40 | 224,572,804.38 | 58,679,604.88 | 2,676,428,488.14 |
| 11 | **Нэйшнл лайф даатгал** | 1,305,802,094.61 | 22,073,000.00 | 0 | 1,283,729,094.61 |
| 12 | **Практикал даатгал** | 3,972,452,081.43 | 377,529,242.83 | 77,993,978.71 | 3,516,928,859.89 |
| 13 | **Соёмбо даатгал** | 4,066,749,913.38 | 329,107,893.22 | 190,350,350.98 | 3,547,291,669.18 |
| 14 | **Тэнгэр даатгал** | 5,691,704,969.93 | 830,198,033.82 | 186,578,143.57 | 4,674,928,792.54 |
| 15 | **Улаанбаатар хотын даатгал** | 977,279,297.41 | 0.00 | 613,500.00 | 976,665,797.41 |
| 16 | **Хаан даатгал** | 2,840,191,043.33 | 27,942,852.93 | 18,550,840.88 | 2,793,697,349.52 |
| | **НИЙТ** | 89,103,866,982.99 | 34,253,881,914.90 | 1,602,434,750.95 | 53,247,550,317.14 |

Тайлант хугацааны даатгалын нийт хураамжийн орлогын 83.8 хувь нь даатгалын 5 хэлбэрийн хураамжийн орлогоос бүрдэж байна. Хураамжийн орлогын бүтцээс үзэхэд нийт хураамжийн 25.6 хувийг хөрөнгийн даатгал, 20.2 хувийг ЖХАЖД, 13.5 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 17 хувийг агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал, 9.5 хувийг гэнэтийн ослын даатгалын хураамж тус тус эзэлж байна.

Хүснэгт-8

**Даатгалын хураамжийн орлого /хэлбэрээр/**

| № | Даатгалын хэлбэр | Даатгалын нийт хураамжийн орлого | | Өсөлт, бууралт /дахин/ |
|---|---|---|---|---|
| | | **2014.09.30** | **2015.09.30** | |
| 1 | Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал | 7,559,625,428.61 | 8,465,675,953.07 | 1.12 |
| 2 | Хөрөнгийн даатгал | 23,175,927,611.25 | 20,999,367,238.30 | 0.91 |
| 3 | Автотээврийн хэрэгслийн даатгал | 14,319,164,029.15 | 11,922,634,964.87 | 0.83 |
| 4 | Ачааны даатгал | 2,775,632,448.19 | 1,069,286,476.82 | 0.39 |
| 5 | Барилга угсралтын даатгал | 948,726,759.51 | 439,307,321.73 | 0.46 |
| 6 | Газар тариалангийн даатгал | 0.0 | 0.0 | - |
| 7 | Мал амьтдын даатгал | 685,620,761.81 | 478,322,456.44 | 0.70 |
| 8 | Агаарын хөлгийн даатгал | 4,484,092,888.31 | 2,819,785,648.66 | 0.63 |
| 9 | Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал | 346,589,305.51 | 282,031,525.65 | 0.81 |
| 10 | Хариуцлагын даатгал | 4,472,467,834.55 | 4,798,820,413.36 | 1.07 |
| 11 | Санхүүгийн даатгал | 3,330,972,942.48 | 2,728,672,576.24 | 0.82 |
| 12 | Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал | 14,243,364,178.43 | 17,998,656,269.12 | 1.26 |
| 13 | Зээлийн даатгал | 1,976,796,698.01 | 577,776,242.52 | 0.29 |
| 14 | Итгэлцлийн даатгал | 60,658,416.00 | 12,847,354.00 | 0.21 |
| 15 | Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал | 0.0 | 0.0 | - |

| 16 | Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал | 0.0 | 0.0 | - |
|---|---|---|---|---|
| 17 | Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал | 2,160,634,799.95 | 15,204,880,447.60 | 7.04 |
| 18 | Хугацаат амьдралын даатгал | 201,118,233.04 | 271,740,562.75 | 1.35 |
| 19 | Насан туршийн даатгал | 0.0 | 0.0 | - |
| 20 | Хуримтлалын даатгал | 80,198,959.29 | 63,092,929.53 | 0.79 |
| 21 | Тэтгэврийн даатгал | 47,583,603.15 | 39,597,893.42 | 0.83 |
| 22 | Эрүүл мэндийн даатгал | 686,905,133.95 | 931,370,708.91 | 1.36 |
| 23 | Аннуити | 0.0 | 0.0 | - |
| | **Нийт** | **81,556,080,031.19** | **89,103,866,982.99** | **1.09** |

Жич: Салбарын хэмжээнд нэг компанийн алдаатай тайлагналаас хамаарч “Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал”-ын хэлбэрээр өнгөрсөн оны мөн үеэс нийт хураамжийн орлого нь 7 дахин өсч 15.2 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсэнээр нэгтгэгдсэн. Тухайн компани тайлагналын алдааг засч, баталгаажуулсан тохиолдолд салбарын нэгтгэлд засвар хийх боломжтой бөгөөд энэ тохиолдолд салбарын нийт хураамжийн орлогын дүнд өөрчлөлт орохгүй юм.

Тайлант хугацаанд даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчдын даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлт нь дараах байдалтай байна.

График-6

## 1.5. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2015 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 49614 даатгалын гэрээнд 27.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Тайлант хугацаанд “Монгол даатгал” ХХК 5.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь хамгийн өндөр бөгөөд нийт нөхөн төлбөрийн 26.5 хувийг эзэлж байна. Даатгалын компаниудын тайлант улирлын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “УБ хотын даатгал” ХХК-ийн нийт нөхөн төлбөр 6.8 дахин, “Мандал женерал даатгал” ХХК-ийн нөхөн төлбөр 3.4 дахин өссөн нь компанийн тухайд өндөр өсөлтийг харуулж байгаа бөгөөд үүнд “УБ хотын даатгал” ХХК-ийн автотээврийн хэрэгслийн даатгалын хэлбэрийн, “Мандал женерал даатгал” ХХК-ийн автотээврийн хэрэгслийн даатгалын болон барилга, угсралтын даатгалын хэлбэрийн нөхөн төлбөрийн огцом өсөлт тус тус нөлөөлсөн байна.

Хүснэгт-9

| № | Даатгалын компани | Нийт нөхөн төлбөр | | Өсөлт, бууралт /дахин/ |
|---|---|---|---|---|
| | | 2014.09.30 | 2015.06.30 | |
| 1 | **Ард даатгал** | 2,120,690,312.2 | 3,012,633,324.8 | 1.4 |
| 2 | **Бодь даатгал** | 2,380,376,234.8 | 2,440,224,764.5 | 1.0 |
| 3 | **Ган зам даатгал** | 51,180,383.0 | 66,372,931.0 | 1.3 |
| 4 | **Гэр даатгал** | 55,757,824.0 | 50,466,637.0 | 0.9 |
| 5 | **Мандал женерал даатгал** | 1,050,789,992.3 | 3,577,846,407.4 | 3.4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 | **Миг даатгал** | 1,971,458,467.0 | 3,222,816,084.1 | 1.6 |
| 7 | **Монгол даатгал** | 7,290,446,651.2 | 6,641,802,697.9 | 0.9 |
| 8 | **Монре даатгал** | 806,987,798.0 | 1,330,142,324.0 | 1.6 |
| 9 | **Мөнх даатгал** | 168,278,839.0 | 60,603,712.0 | 0.4 |
| 10 | **Номин даатгал** | 1,786,581,814.8 | 1,160,632,424.1 | 0.6 |
| 11 | **Нэйшнл лайф даатгал** | 483,763,534.6 | 691,612,493.7 | 1.4 |
| 12 | **Практикал даатгал** | 1,860,906,612.5 | 1,616,588,071.6 | 0.9 |
| 13 | **Соёмбо даатгал** | 1,245,240,494.3 | 1,107,327,658.5 | 0.9 |
| 14 | **Тэнгэр даатгал** | 1,753,321,857.5 | 1,998,290,330.4 | 1.1 |
| 15 | **Улаанбаатар хотын даатгал** | 37,177,955.0 | 252,189,047.0 | 6.8 |
| 16 | **Хаан даатгал** | 295,683,810.0 | 576,628,136.0 | 2.0 |
| | **НИЙТ** | **23,358,642,580.2** | **27,806,177,044.0** | **1.2** |

График-7

Даатгалын хэлбэрээр нь авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 24751 гэрээнд нийт 10.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, авто тээврийн хэрэгслийн даатгалын 12046 гэрээнд 6.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон нь хамгийн өндөр нөхөн төлбөр олгосон даатгалын хэлбэрт тооцогдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад барилга угсралтын даатгалын нөхөн төлбөр 24.6 дахин өссөн нь хамгийн өндөр өсөлттэй байна. Мөн хариуцлагын даатгал, санхүүгийн даатгал, зээлийн даатгал, хуримтлалын даатгалын хэлбэрээр тус тус өмнөх оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт-10

| № | Даатгалын хэлбэр | 2014.09.30 | | 2015.09.30 | | Өсөлт, бууралт /дахин/ |
|---|---|---|---|---|---|---|
| | | Нөхөн төлбөр | Нөхөн төлбөр авсан гэрээний тоо | Нөхөн төлбөр | Нөхөн төлбөр авсан гэрээний тоо | |
| 1 | Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал | 2,263,126,753.86 | 6,802 | 2,761,633,857.56 | 7,490 | 1.22 |
| 2 | Хөрөнгийн даатгал | 1,441,885,499.80 | 2,499 | 1,852,879,856.67 | 2,429 | 1.29 |
| 3 | Автотээврийн хэрэгслийн даатгал | 6,057,271,523.68 | 11,265 | 6,620,645,740.71 | 12,046 | 1.09 |
| 4 | Ачааны даатгал | 128,612,698.70 | 44 | 211,877,122.76 | 23 | 1.65 |
| 5 | Барилга угсралтын даатгал | 62,508,630.00 | 5 | 1,538,322,250.08 | 4 | 24.61 |
| 6 | Мал амьтдын даатгал | 21,633,868.87 | 302 | 45,619,243.71 | 7 | 2.11 |
| 7 | Агаарын хөлгийн даатгал | 94,680,384.71 | 6 | - | - | - |
| 8 | Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал | 4,269,617.00 | 1,134 | 22,676,583.00 | 92 | 5.31 |
| 9 | Хариуцлагын даатгал | 449,964,395.31 | 689 | 249,681,455.20 | 409 | 0.55 |
| 10 | Санхүүгийн даатгал | 1,519,240,732.41 | 2,817 | 1,189,955,802.25 | 217 | 0.78 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11 | Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал | 7,809,886,541.29 | 16,522 | 10,594,084,223.1 | 24,751 | 1.36 |
| 12 | Зээлийн даатгал | 3,048,549,370.79 | 94 | 2,010,757,171.38 | 493 | 0.66 |
| 13 | Итгэлцлийн даатгал | 0.00 | 0 | 5,104,891.00 | 1 | - |
| 14 | Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал | 6,001,836.09 | 6 | 11,326,352.82 | 12 | 1.89 |
| 15 | Хугацаат амьдралын даатгал | 55,536,623.00 | 61 | 80,509,900.13 | 95 | 1.45 |
| 16 | Хуримтлалын даатгал | 74,959,480.65 | 18 | 71,393,144.45 | 33 | 0.95 |
| 17 | Тэтгэврийн даатгал | 29,998,106.96 | 11 | 30,368,574.96 | 9 | 1.01 |
| 18 | Эрүүл мэндийн даатгал | 323,269,323.96 | 523 | 509,340,874.19 | 1463 | 1.58 |
| | Нийт | **23,391,395,387.1** | **42798** | **27,806,177,043.9** | **49,614** | **1.19** |

Жич: Тайлант хугацаанд нөхөн төлбөр гараагүй даатгалын хэлбэрүүдийг дээрх хүснэгтэд оруулаагүй болно.

## 1.6. ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Тайлант хугацаанд даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ 73.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар өссөн боловч 5 даатгалын компанийн нөөц сан буурсан үзүүлэлттэй байна. Салбарын нөөц сангийн өсөлтөд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн нөөц сангийн хэмжээ эерэгээр нөлөөлсөн. Салбарын хэмжээнд “Монгол даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК, “Миг даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК-ууд 5 тэрбум ба түүнээс дээш төгрөгийн нөөц сантай байгаа нь нийлбэр дүнгээрээ салбарын хэмжээнд нийт нөөц сангийн 59.1 хувийг эзэлж байна. Хорооноос даатгалын компаниудын нөөц сангийн актуар тооцооллыг хянаж байгаагаас гадна салбарын хөгжилтэй шууд хамааралтайгаар сүүлийн 5 жилийн хугацаан дахь даатгалын нөөц сангийн тогтмол өсөлтийг дараах графикаас харж болно.

График-8

## 1.7. ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд хохирлын харьцаа нь 31.7 хувьтай байна. Энд давхар даатгалд төлсөн хураамж болон давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг оруулж тооцсон болно. Мөн даатгалын компаниудын хувьд даатгалын цэвэр хураамжийн орлого, даатгагчаас олгосон нөхөн төлбөрийн харьцаагаар тооцоход салбарын хэмжээнд хохирлын харьцаа 46.6 хувьтай байна. Даатгалын компани тус бүрээр авч үзвэл “Монре даатгал” ХХК-ийн хохирлын харьцаа 72.9 хувь байгаа нь хамгийн өндөр, “Мөнх даатгал” ХХК хамгийн бага буюу 13.3 хувийн хохирлын харьцаатай байна. Салбарын хэмжээнд хохирлын харьцаа зохих түвшинд байна гэж үзэж байна.

График-9

**Даатгалын хохирлын харьцаа**

Хүснэгт-11

**Даатгалын компаниудын хохирлын харьцаа**

| № | Даатгалын компани | Нийт орлогод тооцсон хураамж | Даатгагчаас олгосон нөхөн төлбөр | Хохирлын харьцаа |
|---|---|---|---|---|
| 1 | **Ард даатгал** | 4,817,737,598.8 | 3,012,633,324.8 | 62.5% |
| 2 | **Бодь даатгал** | 6,458,048,934.7 | 2,440,224,764.5 | 37.8% |
| 3 | **Ган зам даатгал** | 385,460,217.7 | 66,372,931.0 | 17.2% |
| 4 | **Гэр даатгал** | 237,602,770.3 | 50,466,637.0 | 21.2% |
| 5 | **Мандал женерал даатгал** | 1,950,932,196.1 | 756,884,199.5 | 38.8% |
| 6 | **Миг даатгал** | 5,960,435,283.4 | 3,200,948,155.1 | 53.7% |
| 7 | **Монгол даатгал** | 11,930,826,677.3 | 6,641,802,697.9 | 55.7% |
| 8 | **Монре даатгал** | 1,824,808,730.3 | 1,330,142,324.0 | 72.9% |
| 9 | **Мөнх даатгал** | 456,231,278.0 | 60,603,712.0 | 13.3% |
| 10 | **Номин даатгал** | 2,806,096,041.5 | 1,160,632,424.1 | 41.4% |
| 11 | **Нэйшнл лайф даатгал** | 1,477,158,239.7 | 691,612,493.7 | 46.8% |
| 12 | **Практикал даатгал** | 3,272,242,718.3 | 1,616,588,071.6 | 49.4% |
| 13 | **Соёмбо даатгал** | 3,591,412,825.6 | 1,107,327,658.5 | 30.8% |
| 14 | **Тэнгэр даатгал** | 4,711,944,437.4 | 1,922,498,240.0 | 40.8% |
| 15 | **Улаанбаатар хотын даатгал** | 618,695,907.4 | 252,189,047.0 | 40.8% |
| 16 | **Хаан даатгал** | 2,853,161,263.3 | 576,628,136.0 | 20.2% |
| | **Нийт** | **53,352,795,120.1** | **24,887,554,816.8** | **46.6%** |

Хүснэгт-12

**Давхар даатгалын хураамж, нөхөн төлбөрийг нэмж тооцсон хохирлын харьцаа**

| № | Даатгалын компани | Нийт орлогод тооцсон хураамж+Давхар даатгалын хураамж | Нийт нөхөн төлбөр | Хохирлын харьцаа |
|---|---|---|---|---|
| 1 | **Ард даатгал** | 6,185,394,450.7 | 3,012,633,324.8 | 48.7% |
| 2 | **Бодь даатгал** | 22,706,438,000.3 | 2,440,224,764.5 | 10.7% |
| 3 | **Ган зам даатгал** | 385,460,217.7 | 66,372,931.0 | 17.2% |
| 4 | **Гэр даатгал** | 237,602,770.3 | 50,466,637.0 | 21.2% |
| 5 | **Мандал женерал даатгал** | 6,260,899,598.6 | 3,577,846,407.4 | 57.1% |
| 6 | **Миг даатгал** | 6,726,384,657.6 | 3,222,816,084.1 | 47.9% |
| 7 | **Монгол даатгал** | 21,653,388,155.6 | 6,641,802,697.9 | 30.7% |
| 8 | **Монре даатгал** | 1,852,742,645.7 | 1,330,142,324.0 | 71.8% |
| 9 | **Мөнх даатгал** | 456,231,278.0 | 60,603,712.0 | 13.3% |
| 10 | **Номин даатгал** | 3,030,668,845.9 | 1,160,632,424.1 | 38.3% |
| 11 | **Нэйшнл лайф даатгал** | 1,499,231,239.7 | 691,612,493.7 | 46.1% |
| 12 | **Практикал даатгал** | 3,649,771,961.2 | 1,616,588,071.6 | 44.3% |
| 13 | **Соёмбо даатгал** | 3,920,520,718.8 | 1,107,327,658.5 | 28.2% |
| 14 | **Тэнгэр даатгал** | 5,542,142,471.2 | 1,998,290,330.4 | 36.1% |
| 15 | **Улаанбаатар хотын даатгал** | 618,695,907.4 | 252,189,047.0 | 40.8% |
| 16 | **Хаан даатгал** | 2,881,104,116.3 | 576,628,136.0 | 20.0% |
| | **Нийт** | **87,606,677,035.0** | **27,806,177,044.0** | **31.7%** |

## 1.8. ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

Тайлант хугацаанд даатгалын болон давхар даатгалын компаниудын цэвэр ашиг 3.99 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны мөн үеэс 7 даатгалын компанийн цэвэр ашиг буурсан хэдий ч бусад компанийн хувьд цэвэр ашиг өссөн нь нийт салбарын хувьд өмнөх оны мөн үеэс өсөлттэй гарахад нөлөөлж байна. Салбарын хэмжээнд цэвэр ашиг өсөлттэй гарахад “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-

ийн тайлант үеийн цэвэр ашиг гол нөлөөлөгч хүчин зүйл болсон. Мөн тайлант хугацаанд "Нэйшнл лайф даатгал" ХХК-ийн цэвэр ашиг өмнөх онуудтай харьцуулахад өндөр өсөлттэй гарсан байна.

Хүснэгт-13

| № | Даатгалын компани | Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/ | | |
|---|---|---|---|---|
| | | **2014.09.30** | **2015.09.30** | Өсөлт /бууралт/ |
| 1 | **Ард даатгал** | 421,981,581.10 | -300,810,235.88 | -722,791,816.98 |
| 2 | **Бодь даатгал** | 28,677,850.54 | -532,553,235.64 | -561,231,086.18 |
| 3 | **Ган зам даатгал** | 500,519,077.47 | 246,815,685.28 | -253,703,392.19 |
| 4 | **Гэр даатгал** | 206,513,370.76 | 317,952,388.99 | 111,439,018.23 |
| 5 | **Мандал женерал даатгал** | -262,613,344.20 | 25,310,160.14 | 287,923,504.34 |
| 6 | **Миг даатгал** | 368,673,808.00 | 146,731,984.08 | -221,941,823.92 |
| 7 | **Монгол даатгал** | -896,537,140.70 | 353,722,903.79 | 1,250,260,044.49 |
| 8 | **Монре даатгал** | 73,449,239.37 | -178,310,261.21 | -251,759,500.58 |
| 9 | **Мөнх даатгал** | 3,632,584.00 | 55,108,018.00 | 51,475,434.00 |
| 10 | **Номин даатгал** | 16,562,807.89 | 96,552,414.26 | 79,989,606.37 |
| 11 | **Нэйшнл лайф даатгал** | 59,668,385.62 | 165,098,580.87 | 105,430,195.25 |
| 12 | **Практикал даатгал** | 45,989,525.66 | 299,882,374.63 | 253,892,848.97 |
| 13 | **Соёмбо даатгал** | -258,301,956.60 | 196,412,773.85 | 454,714,730.45 |
| 14 | **Тэнгэр даатгал** | 756,520,375.55 | 381,592,188.74 | -374,928,186.81 |
| 15 | **Улаанбаатар хотын даатгал** | 29,443,559.62 | 26,178,980.91 | -3,264,578.71 |
| 16 | **Хаан даатгал** | 66,802,665.58 | 213,145,625.20 | 146,342,959.62 |
| 17 | **ХАА-н давхар даатгал** | 0.00 | 2,484,427,497.10 | 2,484,427,497.10 |
| | **НИЙТ** | 1,160,982,389.66 | 3,997,257,843.11 | 2,836,275,453.45 |

## 1.9. ДАВХАР ДААТГАЛ

Тайлант хугацаанд "Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК нь давхар даатгалын үйл ажиллагаа явуулаагүй. Харин ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд гадаадын давхар даатгагчид нийт 34.2 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг төлсөн байна. Энэ нь өмнөх оны мөн үеийн дүнгээс 11 тэрбум төгрөгөөр буюу 47.4 хувиар өссөн байна. Нийт даатгалын хураамжаас 38.4 хувийг нь давхар даатгалд төлсөн байгаа нь маш өндөр үзүүлэлт юм. "Бодь даатгал" ХХК-ийн хувьд давхар даатгалын хураамж нь нийт хураамжийнхаа 70 хувийг, "Мандал женерал даатгал" ХХК-ийн хувьд 67 хувийг эзэлж байгаа нь нийт салбарын үзүүлэлтэд хүчтэй нөлөөлсөн. Тайлант хугацаанд давхар даатгагчаас 2.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь нийт нөхөн төлбөрийн 10.5 хувийг эзэлж байна. Сүүлийн 5 жилийн байдлаарх давхар даатгалын хураамжийн өсөлтийг дараах графикаар харуулав.

График-10

## 2. ЕРДИЙН ДААТГАЛ

2015 оны 3 дугаар улирлын байдлаар 15 ердийн даатгалын компани, тэдгээрийн 255 салбар, төлөөлөгчийн газар Улаанбаатар хот, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

### 2.1. ЕРДИЙН ДААТГАГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ

Ердийн даатгалын 15 компанийн нийт хөрөнгийн хэмжээ тайлант үеийн байдлаар 137.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Сүүлийн жилүүдийн нийт хөрөнгийн тогтмол өсөлт нь даатгалын салбарын гол гол үзүүлэлтүүдийн өсөлттэй шууд хамааралтай бөгөөд сүүлийн 2 жилийн байдлаар өмнөх онуудтай харьцуулахад өсөлтийн хурд буурах хандлага ажиглагдаж байна.

График-11

### 2.2. ЕРДИЙН ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид өр төлбөр болон эзэмшигчдийн өмчийн эзлэх хувийг дараах графикаар харуулав. Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн талаар 1.3 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

График-12

### 2.3. ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 14 даатгалын хэлбэрээр 87.8 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлж, үүнээс давхар даатгалд 34.2 тэрбум төгрөгийн хураамж шилжүүлж, 1.6 тэрбум төгрөгийн хураамжийг даатгуулагч нарт буцаан олгосноор 51.9 тэрбум төгрөгийн цэвэр хураамжийн орлого төвлөрүүлсэн байна. Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлогын талаар 1.4 дэх хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Ердийн даатгалын нийт хураамжийн орлогыг даатгалын хэлбэрээр ангилж, дараах графикаар харуулав.

График-13

### 2.4. ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 27.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон бөгөөд энэ нь салбарын нийт нөхөн төлбөрийн 97.5 хувийг эзэлж байна. Даатгалын нөхөн төлбөрийн талаар 1.5 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Мөн давхар даатгагчаар 2.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр төлүүлсэн бөгөөд даатгагчдийн хувьд олгосон нөхөн төлбөрийн 46.5 хувь буюу 12.6 тэрбум төгрөгийг даатгалын нөөц сангаас, 42.8 хувь буюу 11.6 тэрбум төгрөгийг орлогод тооцсон хураамжаас тус тус олгосон байна.

## 2.5. ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРЛЫН ХАРЬЦАА, АШИГТ АЖИЛЛАГАА

Ердийн даатгагчдын хохирлын харьцааг өмнөх оны мөн үетэй харьцуулж харуулав.

Хүснэгт-14

| № | Даатгалын компани | Хохирлын харьцаа | | Өсөлт /бууралт/ |
|---|---|---|---|---|
| | | 2014.09.30 | 2015.09.30 | |
| 1 | **Ард даатгал** | 37.1% | 62.5% | 25.4 |
| 2 | **Бодь даатгал** | 35.3% | 37.8% | 2.5 |
| 3 | **Ган зам даатгал** | 12.6% | 17.2% | 4.6 |
| 4 | **Гэр даатгал** | 19.4% | 21.2% | 1.8 |
| 5 | **Мандал женерал даатгал** | 37.9% | 38.8% | 0.9 |
| 6 | **Миг даатгал** | 45.8% | 53.7% | 7.9 |
| 7 | **Монгол даатгал** | 51.3% | 55.7% | 4.4 |
| 8 | **Монре даатгал** | 50.3% | 72.9% | 22.6 |
| 9 | **Мөнх даатгал** | 38.5% | 13.3% | -25.2 |
| 10 | **Номин даатгал** | 56.0% | 41.4% | -14.7 |
| 11 | **Практикал даатгал** | 55.1% | 49.4% | -5.7 |
| 12 | **Соёмбо даатгал** | 34.5% | 30.8% | -3.7 |
| 13 | **Тэнгэр даатгал** | 38.3% | 40.8% | 2.5 |
| 14 | **Улаанбаатар хотын даатгал** | 2.7% | 40.8% | 38.0 |
| 15 | **Хаан даатгал** | 16.0% | 20.2% | 4.2 |
| | **Нийт /дундаж/** | 42.0% | 46.6% | 4.6 |

Тайлант хугацааны ердийн даатгалын компаниудын ашигт ажиллагааг 1.8 дахь хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан. Сүүлийн 5 жилийн 3 дугаар улирлын байдлаар тайлант үеийн цэвэр ашиг, хуримтлагдсан ашгийг дараах графикаар харуулав.

График-14

## 2.6. ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН, ДАВХАР ДААТГАЛ

Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын нөөц сан 65.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. Ердийн даатгалын төрлөөр нөөц сан тус бүрийн дүнг дараах байдлаар харуулав.

Хүснэгт-15

| Ердийн даатгалын төрөл | Ердийн даатгалын нөөц сан | 2015-III |
|---|---|---|
| Сайн дурын даатгал | Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн сан | 22,474,768,596.02 |
| | Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан | 8,251,202,028.27 |
| | Нэхэмжилсэн хохирлын нөөц сан | 377,170,338.57 |

| | | |
|---|---|---|
| | Учирч болзошгүй хохирлын нөөц сан | 19,181,871,443.34 |
| Албан журмын даатгал | Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн сан | 11,125,626,491.61 |
| | Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан | 1,931,988,376.24 |
| | Нэхэмжилсэн хохирлын нөөц сан | 72,034,314.91 |
| | Учирч болзошгүй хохирлын нөөц сан | 1,929,958,785.47 |
| | **Нийт нөөц сангийн дүн** | **65,344,620,374.43** |

График-15

**Ердийн даатгалын төрлөөр нөөц сангийн харьцаа**

Ердийн даатгагчид өөрт хүлээх эрсдэлийг хэсэгчлэн гадаадын давхар даатгагчид даатгуулахад тайлант хугацаанд 34.2 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 51.2 хувиар өссөн байна. Давхар даатгалын талаар 1.9 дэх хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан.

Хүснэгт-16

| № | Даатгалын компани | Давхар даатгалын хураамж | | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| | | 2014.09.30 | 2015.09.30 | |
| 1 | **Ард даатгал** | 1,420,375,583.98 | 1,367,656,851.83 | -52,718,732.15 |
| 2 | **Бодь даатгал** | 7,443,419,400.00 | 16,248,389,065.60 | 8,804,969,665.60 |
| 3 | **Ган зам даатгал** | 0.00 | 0.00 | 0.00 |
| 4 | **Гэр даатгал** | 0.00 | 0.00 | 0.00 |
| 5 | **Мандал женерал даатгал** | 3,081,574,120.37 | 4,309,967,402.43 | 1,228,393,282.06 |
| 6 | **Миг даатгал** | 868,704,100.00 | 765,949,374.21 | -102,754,725.79 |
| 7 | **Монгол даатгал** | 7,597,192,531.99 | 9,722,561,478.29 | 2,125,368,946.30 |
| 8 | **Монре даатгал** | 148,697,421.37 | 27,933,915.36 | -120,763,506.01 |
| 9 | **Мөнх даатгал** | 0.00 | 0.00 | 0.00 |
| 10 | **Номин даатгал** | 216,305,731.56 | 224,572,804.38 | 8,267,072.82 |
| 11 | **Практикал даатгал** | 119,836,124.55 | 377,529,242.83 | 257,693,118.28 |
| 12 | **Соёмбо даатгал** | 267,741,546.00 | 329,107,893.22 | 61,366,347.22 |
| 13 | **Тэнгэр даатгал** | 912,465,822.56 | 830,198,033.82 | -82,267,788.74 |
| 14 | **Улаанбаатар хотын даатгал** | 0.00 | 0.00 | 0.00 |
| 15 | **Хаан даатгал** | 129,232,813.00 | 27,942,852.93 | -101,289,960.07 |
| | **НИЙТ** | **22,205,545,195.38** | **34,231,808,914.90** | **12,026,263,719.52** |

## 3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

### 3.1. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

“Нэйшнл лайф даатгал” ХХК нь 2008 оноос хойш урт хугацааны даатгалын үйл ажиллагаа явуулж байна. Тус компанийн хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилийн байдлаар тогтмол өсөлттэй байгаа бөгөөд тайлант хугацаанд 6.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.

График-16

### 3.2. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨР

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн даатгалын хураамжийн орлого тайлант хугацаанд 1.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онуудын тогтмол өсөлтийг хангасан байна. Тайлант хугацааны нөхөн төлбөр мөн өсч 691.6 сая төгрөгт хүрсэн бөгөөд урт хугацааны даатгагчийн хохирол нөхөлтийн харьцаа 46.8 хувьтай байна. Тайлант улирлын урт хугацааны даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, тэдгээрийн харьцааг сүүлийн жилүүдтэй харьцуулав.

График-17

### 3.3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ

Давхар даатгалын хураамжид тайлант хугацаанд 22 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Урт хугацааны даатгалын сүүлийн 5 жилийн давхар даатгалын хураамжийг графикаар харуулав.

График-18

### 3.4. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН НӨӨЦ САН, АШИГТ АЖИЛЛАГАА

Урт хугацааны даатгалын хэмжээ болон хураамжийн орлогын тогтмол өсөлттэй холбоотой даатгалын нөөц сангийн хэмжээ нь тогтмол өсч байна. Тайлант хугацаанд даатгагчийн нөөц сан 1.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 15.4 хувиар өссөн байна.

График-19

“Нэйшнл лайф даатгал” ХХК нь урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж эхэлснээс хойш алдагдалтай ажиллаж байсан бөгөөд 2014 оноос эхлэн ашигтай ажиллаж, 2015 оны 3 дугаар улирлын байдлаар 165.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Урт хугацааны даатгагчийн ашигт ажиллагааг сүүлийн 5 жилийн эцсийн байдлаар дараах графикаар харуулав.

График-20

## 4. АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

2015 оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /цаашид “жолоочийн хариуцлагын даатгал” гэх/-ын үйл ажиллагаа эрхэлж байна. Жолоочийн хариуцлагын даатгалаар даатгалын компаниуд тайлант улиралд 17.99 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 3.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд жолоочийн хариуцлагын даатгалын 24751 тохиолдолд нийт 10.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Албан журмын болон сайн дурын даатгалын нийт хураамжийн орлого, нийт нөхөн төлбөрийг харьцуулж харуулав.

График-21

Сүүлийн 3 жилийн 3 дугаар улирлын байдлаар жолоочийн хариуцлагын даатгалын 1 гэрээ тутамд ногдож буй даатгалын тохиолдол болох магадлал нь дараах байдалтай байна.

График-22

**ЖХАЖД-ын тохиолдол**

## 5. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

### 5.1. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

Тайлант хугацаанд 26 даатгалын зуучлагч компани, 8 банк даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж нийт 3 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий ердийн даатгалын 11, урт хугацааны даатгалын 1 бүтээгдэхүүнийг зуучилж, 15.8 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн нь салбарын нийт хураамжийн орлогын 17.7 хувийг эзэлж байна. Даатгалын зуучлалын орлого нь өмнөх оны мөн үеэс 46.2 хувиар өсч, 3.4 тэрбум төгрөгт хүрчээ.

Даатгалын компаниуд болон даатгалын зуучлагч компаниудын тайлагналаас хамаарч даатгалын зуучлагчаар дамжиж орсон даатгалын хураамжийн орлого улирал бүр зөрүүтэй гарч байна.

График-23

Хүснэгт-17

| № | Даатгалын зуучлагч компани | Зуучилсан даатгалын хураамжийн орлого | Даатгалын зуучлалын орлого | Зуучилсан даатгалын хураамжийн орлого | Даатгалын зуучлалын орлого |
|---|---|---|---|---|---|
| | | 2014.09.30 | | 2015.09.30 | |
| 1 | Эрсдэлийн шийдэл | 2,794,640,980.0 | 806,317,681.7 | 2,152,455,300.7 | 591,659,390.3 |
| 2 | Худалдаа хөгжлийн банк | - | - | 2,131,502,175.5 | 299,637,961.0 |
| 3 | Хаан банк | 2,522,143,153.0 | 483,780,021.0 | 1,858,118,233.0 | 428,001,936.0 |
| 4 | Сүрэг хараацай | 352,611,106.0 | 74,268,789.0 | 1,354,672,393.0 | 336,701,473.0 |
| 5 | Үндэсний хөрөнгө оруулалтын банк | - | - | 1,136,651,040.8 | 291,145,341.5 |
| 6 | Төрийн банк | 519,410,828.9 | 116,219,524.8 | 1,048,795,732.0 | 228,448,710.4 |
| 7 | Голомт банк | - | - | 1,011,429,119.7 | 151,714,368.0 |
| 8 | ХасБанк | 218,272,620.7 | 40,178,079.8 | 966,339,933.4 | 193,088,905.2 |
| 9 | Ваяснью Солюшн | 15,617,372.0 | 2,701,175.0 | 767,877,915.0 | 100,621,823.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | Асимон брокерс | 1,255,907,506.0 | 96,179,333.6 | 674,285,259.0 | 93,321,844.4 |
| 11 | Лояалти солюшн | 550,814,420.2 | 172,504,833.0 | 498,290,975.4 | 168,712,735.0 |
| 12 | Нэйшнл эженси | 190,604,286.0 | 28,590,643.0 | 477,177,610.0 | 59,123,123.0 |
| 13 | Гэрэлт буян ундрах | 644,059,700.0 | 188,288,900.0 | 449,280,294.0 | 135,002,736.5 |
| 14 | Си эн эн икс | 3,600,692,282.4 | 148,815,167.7 | 352,059,905.8 | 59,447,528.3 |
| 15 | Ачит ундарга | 347,689,284.0 | 101,471,417.2 | 318,492,382.2 | 65,942,374.7 |
| 16 | Ариг банк | 7,324,725.5 | 1,831,181.4 | 159,527,409.8 | 35,089,645.5 |
| 17 | Капитал банк | 19,017,480.2 | 4,754,370.1 | 152,440,762.0 | 23,687,832.0 |
| 18 | Мастер шийдэл | - | - | 86,223,050.0 | 20,776,732.2 |
| 19 | Эл Би брокерэж | - | - | 66,335,482.0 | 9,391,877.0 |
| 20 | Арм интернэшнл | - | - | 51,717,436.0 | 15,521,387.0 |
| 21 | Монгол бичээч зууч | - | - | 18,904,936.0 | 8,293,642.0 |
| 22 | Хүннү сиэл | 18,385,071.0 | 7,348,041.0 | 16,868,822.9 | 4,107,222.3 |
| 23 | Эм жи ай би | - | - | 7,522,720.0 | 1,504,544.0 |
| 24 | Соёомбо Ай Би | 15,505,708.0 | 4,359,033.0 | 1,989,327.0 | 516,081.9 |
| 25 | Эс ай би эс | 1,435,850.0 | 405,128.0 | 900,000.0 | 135,000.0 |
| 26 | Дэвжих дэлгэрэх холдинг | - | - | 639,000.0 | 150,000.0 |
| 27 | Эй Эс Ай Би | - | - | 500,000.0 | 100,000.0 |
| 28 | AME | 7,332,633.0 | 1,466,526.6 | 0.0 | 70,888,500.1 |
| 29 | Ар Эм Ай Би | - | - | - | - |
| 30 | Түвшин ориент | - | - | - | - |
| 31 | Ренессанс групп | 258,726,632.1 | 40,893,710.5 | - | -- |
| 32 | Монголиан интернэшнл брокерс | - | - | - | - |
| 33 | Цагаан гэрэлт | - | - | - | - |
| 34 | Тус брокерс | - | - | - | - |
| | **ДҮН** | **13,340,191,639.1** | **2,320,373,556.2** | **15,760,997,214.9** | **3,392,732,714.1** |

*Тэмдэглэл: - үйл ажиллагаа эрхлээгүй*

## 5.2. ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Тайлант хугацаанд даатгалын хохирол үнэлэгч 23 компани нийт 5 тэрбум төгрөгийн даатгалын хохирлын хэмжээ бүхий 14833 удаагийн даатгалын хохирлын үнэлгээ хийж, 353.8 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлого төвлөрүүлжээ. Нийт дүнгээрээ даатгалын хохирол үнэлгээний орлого өмнөх оны мөн үеэс 20 орчим хувиар буурсан байна.

Хүснэгт-18

| № | Компани | Даатгалын хохирол үнэлгээний орлого | |
|---|---|---|---|
| | | **2014.III** | **2015.III** |
| 1 | Арвижих эстимэйт | 25,727,250.00 | 17,430,785.12 |
| 2 | Арга билэг эстимэйт | 250,000.00 | - |
| 3 | Ашид билгүүн | 168,905,050.00 | 49,104,200.00 |
| 4 | Бэст эстимэйт | 14,494,545.46 | 9,020,000.00 |
| 5 | Вендо | 81,332,363.00 | 93,104,782.00 |
| 6 | Гэрэгэ эстимэйт | 66,280,019.00 | 46,870,636.00 |

Даатгалын зохицуулалтын газар: Даатгалын салбарын 2015 оны 3 дугаар улирлын нэгдсэн танилцуулга

| | | | |
|---|---|---|---|
| 7 | Жи эй си си | 12,192,727.26 | 10,436,363.63 |
| 8 | Итгэлт эстимэйт | 36,462,729.00 | 13,473,637.00 |
| 9 | Капитал эстимэйт | - | 860,000.00 |
| 10 | Кости эстимэйт | - | 15,482,000.00 |
| 11 | Лэндс | 650,000.00 | 24,115,000.00 |
| 12 | Мастер Үнэлгээ | 4,774,000.00 | 23,192,000.00 |
| 13 | Мега марз | 7,930,682.00 | 3,522,500.00 |
| 14 | Сэлэнгэ эстимэйт | 12,294,100.00 | - |
| 15 | Тэгшсонголт эстимэйт | - | 813,636.36 |
| 16 | Ухаашүрт консалтинг | 2,637,000.00 | 27,858,181.00 |
| 17 | Файн эстимэйт | 1,081,500.00 | 2,700,000.00 |
| 18 | Фэйр валуэшн | 278,000.00 | - |
| 19 | Хас үнэлгээ | - | - |
| 20 | Хос стандарт | 5,164,500.00 | 6,150,000.00 |
| 21 | Хөрөнгө үнэлгээний төв | 600,000.00 | 380,000.00 |
| 22 | Хөрөнгө эстимэйт | - | 9,312,000.00 |
| 23 | Юу Энд Эн | - | - |
| | **Нийт** | 441,054,465.72 | 353,825,721.11 |

*Тэмдэглэл: - үйл ажиллагаа эрхлээгүй*

## 6. <u>ДҮГНЭЛТ</u>

Монгол улсын арилжааны даатгалын салбарын 2015 оны 3 дугаар улирлын санхүү, даатгалын үйл ажиллагааны нэгдсэн танилцуулгыг гаргаж, салбарын гол үзүүлэлтүүдийг өмнөх улирал, сүүлийн жилүүдийн мөн үетэй, зарим үзүүлэлтийг сүүлийн жилүүдийн жилийн эцсийн тоон мэдээлэлтэй харьцуулж, дүгнэсэн.

Тайлант хугацаанд даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө 169.6 тэрбум төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 81.1 хувийг ердийн даатгалын компаниуд, 4 хувийг урт хугацааны даатгалын компани, 14.9 хувийг давхар даатгалын компани эзэлж байна. Нийт хөрөнгийг өмнөх тайлант он буюу 2014 оны 4 дүгээр улиралтай харьцуулахад 17.1 тэрбум төгрөгөөр буюу 11.2 хувиар өссөн хэдий ч 2015 оны 2 дугаар улиралтай харьцуулахад 1 тэрбум гаруй төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Үүнд өмнөх улирлын нийт хөрөнгөөс 100 сая болон түүнээс дээш төгрөгөөр буурсан 5 даатгалын компанийн нийт хөрөнгийн бууралт гол нөлөөлсөн байна. Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөр 1.4 тэрбум төгрөгөөр буурч, нөөц сан 7.8 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 28.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Өмнөх оноос хамгийн өндөр өсөлттэй буюу 45.1 хувиар өссөн

эзэмшигчдийн өмчийн өсөлтөд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн эзэмшигчдийн өмчийн дүн гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант хугацаанд даатгалын компаниуд 89.1 тэрбум төгрөгийн даатгалын нийт хураамжийн орлого төвлөрүүлж, 27.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь үнийн дүнгийн хувьд өмнөх жилүүдээс өссөн хэдий ч өмнөх оны мөн үеэс өссөн өсөлтийн хувь нь сүүлийн 5 жилийн дундаж өсөлтөөс доогуур байна. Эдгээр үзүүлэлтээс бусад гол гол үзүүлэлтүүдийн хувьд өсөлтийн хурд мөн адил удааширсан байдал ажиглагдаж байна.

Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүрүүд болох даатгалын нэвтрэлт, нягтрал нь олон улсын дунджаас харьцангуй доогуур үзүүлэлттэй, мөн сүүлийн жилүүдэд тодорхой өсөлт ажиглагдахгүй байна. 2015 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын нийт хураамжийн орлого ДНБ-ний 1.46 хувьтай тэнцүү, нэг хүнд ногдох даатгалын нийт хураамжийн орлого ойролцоогоор 29.2 мянган төгрөг байна. Өмнөх жилүүдийн статистикээс харахад даатгалын нэвтрэлтийн хувьд 2015 оны жилийн эцсийн ДНБ-ний дүнгээс хамаарч 1 хувиас бага, өмнөх жилүүдтэй ойролцоо 0.5 орчим хувь байх магадлалтай юм.

Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүдийн өсөлтийн хурд буурч байгааг улс орны эдийн засгийн нөхцөлтэй уялдуулж болох боловч гол нөлөөлж буй хүчин зүйл нь зах зээлийн хамрах хүрээ юм. Салбарын хэмжээнд 2011-2013 оны хооронд гарсан огцом өсөлт нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай шууд хамааралтай байсан. Гэвч сүүлийн 2 жилийн хугацаанд салбарын хэмжээнд өсөлтийн хурд буурч байгаа нь зах зээлийн хамрах хүрээ төдийлөн тэлэхгүй байгаатай холбоотой тул цаашид төрөөс баримтлах бодлого, зохицуулалтыг салбарын үйл ажиллагааны болон зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх, урт хугацааны даатгалын хөгжил, ердийн даатгалын бүтээгдэхүүний хүртээмжийг дээшлүүлэх, албан журмын даатгалын шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх талаар судлах, иргэдийн даатгалын боловсролыг дээшлүүлэх зэрэг асуудлуудад чиглүүлэх шаардлагатай байна.

ДААТГАЛЫН БОДЛОГЫН ХЭЛТЭС